



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 5/21

Бор-өндөр сум

О.Ариунжаргалыг архив,  
бичиг хэргийн ажилтнаар түр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 48 дугаар зүйлийн 48.1, 50 дугаар зүйлийн 50.1.2, Засгийн газрын 2019 оны "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" 276 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, 2022 оны "Журамд өөрчлөлт оруулах тухай" 491 дүгээр тогтоол, Нэгдсэн эмнэлгийн даргын 2023 оны "Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний ажилчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Б/05 тоот тушаалын хавсралт, Эрүүл мэндийн сайдын 2018 оны "Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдын хоол унааны хөнгөлөлт, нэмэгдэл, урамшлын хэмжээг тогтоох тухай" А/548 тоот тушаал, 2020 оны "Хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах тухай" А/69 дугаар тушаал, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Отгоны Ариунжаргалыг 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн Архив, бичиг хэргийн ажилтнаар 3 сарын хугацаатай түр томилон ажиллуулсугай.
2. О.Ариунжаргалыг 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн ТҮ5-2 шатлалаар тогтоон үндсэн цалинг 823.967 (найман зуун хорин гурван мянга есөн зуун жаран долоо), төрийн алба хаасан хугацааны нэмэдэл 6% 49.438 (дөчин есөн мянга дөрвөн зуун гучин найм), хоолны мөнгө өдрийн 3000 (гурван мянга) төгрөгөөр тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Т.Эрдэнэболор)-т зөвшөөрсүгэй.
3. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажиллахыг О.Ариунжаргалд үүрэг болгосугай.

ДАРГА

А.БАТБААТАР

